



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 104

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,
үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 157,690,060 /нэг зуун тавин долоон сая зургаан зуун ерэн мянга жаран/ төгрөгийн балансын үнэтэй, 35,151,742.34 /гучин таван сая нэг зуун тавин нэгэн мянга долоон зуун дөчин хоёр төгрөг гучин дөрвөн мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хуучин эмнэлэгийн барилгыг нэгдүгээр хавсралтаар акталж, устган, данснаас хасах, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, 4,800,000 /дөрвөн сая найман зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй зоорийн барилгын худалдах доод үнийг 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгөөр, 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй уурын зуухны барилгын худалдах доод үнийг 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тогтоон хоёрдугаар хавсралтаар нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, 49,500,000 /дөчин есөн сая таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 20-48 ДУА улсын дугаартай TOYOTA Land Cruiser 80 маркын автомашиныг гуравдугаар хавсралтаар, худалдах доод үнийг 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 2011 онд үйлдвэрлэгдсэн бага оврын тракторыг 80,000 /наян мянга/ төгрөгөөр сэлбэгэнд худалдах, 1,900,000 /нэг сая есөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 2008 онд үйлдвэрлэгдсэн пад пад тракторыг дөрөвдүгээр хавсралтаар акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Дэлгэрцогт сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

Гурав. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга), Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын дарга (С.Нарантунгалаг)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Дуудлагын худалдааг зохих хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр ханган, хяналт тавин ажиллах;

3.2 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг төмрийн хаягдалд тушаан, орлогыг аймгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэх;

3.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

3.4 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын
22-ний өдрийн... тогтоолын нэгдүгээр хавсралт

Дэлгэрцөгт сумын Засаг даргын тамгын газрын актлах барилгын мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтанд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Актлах төрөл /1. Устгах 2. Худалдах 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4. бусад/
			хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Хуучин эмнэлэг	Эмнэлэг	ш	1	1989.01.01	40	157,690,060	122,538317.66	1
35,151,742.34 35,151,742.34 Гучин таван сая нэг зуун тавин нэгэн мянга долоон зуун дөчин хоёр төгрөг гучин дөрвөн ионгө/									
Дүн									

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын
22-ний өдрийн 40... Тогтоолын хоёрдугаар хавсралт



Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын дуудлагаар худалдах барилгын мэдээлэл


д/д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалта нд орсон огноо	Ашиглалты н нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлаг дсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Актлах төрөл /1. Устгах 2. Худалдах 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4. бусад/
			хэм жих нэгж	Биет хэмжэ э						
1	Зоорь	Хүнсний	ш	1	2009.06.30	12	4,800,000	4,800,000	-	2
2	Уурын зуухны барилга	Уурын зуух	ш	1			100,000	100,000	-	2

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021-оны 07 дугаар сарын
22-ний өдрийн 024 тогтоолын гуравдугаар хавсралт



Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглагдсан орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Серий	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	Toyota Land Cruiser 80	ДУ А	20-48	2014	2014	ЖТJHT00W343539 308	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/	2.5	49,500,000	49,500,000	-



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын
22-ний өдрийн 102/А тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын акталж, сэлбэгээр худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар		Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Трактор бага овор				2011	2011				4,500,000	4,500,000	-

Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын акталж, даннаас хасах тээврийн хэрэгслийн мэдээлэл

2	Пад трактор				2008	2008				1,900,000	1,900,000	
---	-------------	--	--	--	------	------	--	--	--	-----------	-----------	--